



Улсын нэгдсэн бүртгэлийн 2014...оны 12-р
сарын 04-ны одрийн 3501 дугаарт бүртгэв.
Монгол Улсын Хууль зүйн яам

**ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/226

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Харьяатын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалтыг нэгдүгээр, Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудасны загварыг хоёрдугаар, Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудасны загварыг гуравдугаар, Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Жагсаалт батлах тухай" Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны даргын 2002 оны 94 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний харьяаллын газар /А.Энх-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ПҮРЭВДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХАРЬААЛЛЫН АСУУДЛЫГ
ШИЙДВЭРЛЭХЭД ШААРДАГДАХ БИЧИГ БАРИМТЫН
ЖАГСААЛТ**

**Нэг. Иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд
шаардагдах бичиг баримт**

1.1. Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагч дор дурдсан бичиг баримт бүрдүүлнэ:

1.1.1. өргөдөл (өргөдлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргах бөгөөд Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох шалтгаан, аль улсад ямар хугацаагаар ажиллаж, амьдарч байсан, хэзээ, ямар хэргээр тус улсад ирсэн, эцэг, эх, эхнэр /нөхөр/, хүүхэд нь аль улсын харьяат болох, өргөдөл гаргагч одоо аль улсад аж төрж байгаа зэрэг өөрийн болон ам бүлийнхээ байдлыг тодорхой тусгана);

1.1.2. гурван үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхрийн, эцэг, эхийн, өвөг эцэг, эмэг эхийн);

1.1.3. мэдүүлгийн хуудас;

1.1.4. Монгол Улсад оршин суух үнэмлэхийн хуулбар;

1.1.5. төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гадаад паспорт, 16 хүртэл насны хүүхэдтэй бол хүүхдийн төрсний гэрчилгээний тус тус нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.1.6. гэр бүлтэй бол гэрлэлтийн гэрчилгээний, гэрлэлтээ цуцлуулсан бол энэ тухай эрх бүхий байгууллагаас гаргасан албан ёсны шийдвэрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.1.7. эцэг эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат болохдоо 16 нас хүрээгүй хүүхдээ тус улсын харьяат болгох хүсэлтэй тохиолдолд эцэг эхийн бичгээр гаргасан үндэслэл бүхий тохиролцоог нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.1.8. 16-18 насны хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх тохиолдолд түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.1.9. Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан хүсэлт гаргагчийн хувьд түүнийг харьяалах улсын эрх бүхий байгууллагын буюу тухайн улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын тодорхойлолт, орчуулгын хамт;

1.1.10. сэтгэц мэдрэлийн буюу халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын талаарх эрүүл мэндийн /сэтгэцийн эрүүл мэндийн болон халдварт

өвчин судлалын үндэсний төв, орон нутагт эрүүл мэндийн нэгдсэн төв/ байгууллагын тодорхойлолт;

1.1.11. хууль ёсны амьжиргааны эх үүсвэртэй болохыг нотлох зохих бичиг баримт;

1.1.11.1. байгууллага, аж ахуйн нэгжээс гаргасан цалингийн тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.1.11.2. хувиараа хөдөлмөр эрхлэгч бол түүний орлогынх нь талаархи банк, татварын байгууллагын тодорхойлолт, байгууллагын гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.1.11.3. үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.1.11.4. амьжиргааны эх үүсвэртэй болохыг нотлох бусад.

1.1.12. оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт (хаяг, ам бүлийн);

1.1.13. гэрэл зураг 3 хувь;

1.1.14. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

1.2. Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргагч нь дор дурдсан бичиг баримт бүрдүүлнэ:

1.2.1. өргөдөл (өргөдлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргах бөгөөд Монгол Улсын харьяатаас гарах болсон шалтгаан, харьяат болохыг хүссэн улс, харьяат болох улсдаа шилжин суурьшсан огноо, эцэг, эх, эхнэр /нөхөр/, хүүхэд нь аль улсын харьяат болох, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх эсэх талаар тусгана);

1.2.2. гурван үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхрийн, эцэг, эхийн, өвөг эцэг, эмэг эхийн);

1.2.3. мэдүүлгийн хуудас;

1.2.4. төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гадаад паспорт, 16 хүртэл насны хүүхэдтэй бол хүүхдийн төрсний гэрчилгээний тус тус нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.2.5. гэр бүлтэй бол гэрлэлтийн гэрчилгээний, гэрлэлтээ цуцлуулсан бол энэ тухай эрх бүхий байгууллагаас гаргасан албан ёсны шийдвэрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.2.6. 16 хүртэл насны хүүхдийнхээ иргэний харьяаллыг өөрчлөх бол энэ талаар эцэг эхийн харилцан бичгээр тохиролцсон зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.2.7. 16-18 насны хүүхдийн иргэний харьяаллыг өөрчлөх тохиолдолд түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

1.2.8. Монгол Улсын иргэний харьяаллаас гарсан тохиолдолд өөрийн харьяаллыг олгохыг зөвшөөрсөн тухайн гадаад улсын эрх бүхий холбогдох байгууллагын албан ёсны зөвшөөрөл, орчуулгын хамт;

1.2.9. Монгол Улсад иргэний өр төлбөр, нэхэмжлэлгүй болох талаар дараах байгууллагуудаас гаргасан тодорхойлолт;

1.2.9.1. шүүх;

1.2.9.2. шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;

1.2.9.3. татварын байгууллага;

1.2.9.4. сургалтын төрийн сан.

1.2.10. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

1.2.11. гэрэл зураг 3 хувь.

1.3. Харьяатын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагчаас энэ жагсаалтын 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан зохих бичиг баримтыг шаардана.

1.4. Иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргагч нь гэр бүлийн гишүүдийн хамт Монгол Улсын харьяат болох, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох, харьяатаас гарахыг хүсвэл өргөдлөө хамтран гаргаж болно.


Хоёр. Бусад

2.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газар, тус улсын холбогдох байгууллагын тодорхойлолтод хүсэлт гаргагчийн тухайн улсад хэдэн жил оршин сууж, аж төрж буй байдал, хаяг, ам бүлийн байдал, амьжиргааны эх үүсвэр, нийгмийн дэг журам хэр сахиж, иргэний үүргээ хэрхэн биелүүлдэг, монгол хэл, зан заншил, хууль тогтоомжийн талаарх мэдлэг зэргийг тодорхой тусгана.

2.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргасан өргөдөл, гурван үеийн намтар, мэдүүлгийн хуудас нь хоорондоо зөрүүгүй, үнэн зөв, он дарааллын дагуу тодорхой, дэлгэрэнгүй бичнэ.

2.3. Хуулбар баримт бичгүүд нь нотариатаар гэрчлэгдсэн, гадаад хэл дээрх баримт бичгүүд нь албан ёсоор орчуулагдсан байна.

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний
ерөнхий газрын даргын 2014 оны
А/226 дугаар тушаалын II хавсралт



Хар өнгийн бэхээр гаргацтай, үнэн зөв бөглөнө.


МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТ БОЛОХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН
МЭДҮҮЛГИЙН ХУУДАС

Овог _____

Эцэг (эхийн) нэр _____

Өөрийн нэр _____

Зураг



1. Овог нэр (паспортад бичигдсэнээр)

2. Төрсөн газар, огноо

3. Иргэний харьяалал

4. Яс, үндэс

5. Хүйс

6. Боловсрол, мэргэжил (хаана, ямар сургуулийг хэдээс хэдэн онд суралцаж төгссөн)

7. Ажил эрхлэлтийн байдал (хаана, ямар байгууллагад хэдээс хэдэн онд ямар ажил хийж байсан, одоо ямар ажил хийж байгаа)

8. Ам бүлийн байдал (иргэний харьяалал, овог нэр, төрсөн огноо, оршин суугаа газар)



9. Шүүхээр шийтгэгдэж байсан эсэх (шийтгэгдэж байсан бол ямар ял шийтгэл хүлээж байсан)

10. Монгол Улсын харьяат болох шалтгаан

11. Таныг дагалдаж таны гэр бүлийн гишүүн Монгол Улсын харьяат болох эсэх

12. Монгол Улсад анх ирсэн огноо, зорилго

13. Таны төрөл садан Монгол Улсад амьдардаг эсэх (таны хэн болох, хаана амьдардаг)

14. Амьжиргааны эх үүсвэр

15. Байнга оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг

Миний хамт Монгол Улсын харьяат болох
18-аас доош насны хүүхэд


№	Овог нэр	Хүйс	Төрсөн газар, он сар, өдөр	Ургийн холбоо
1				
2				
3				
4				

Мэдүүлгийн хуудсыг үнэн зөв бичсэн _____

20...оны ... сарын ...өдөр



Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний
ерөнхий газрын даргын 2014 оны
А/226 дугаар тушаалын III хавсралт



Хар өнгийн бэхээр гаргацтай, үнэн зөв бөглөнө.


МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХАРЬААЛЛАА СЭРГЭЭН
ТОГТООЛГОХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МЭДҮҮЛГИЙН ХУУДАС

Овог _____

Эцэг (эхийн) нэр _____

Өөрийн нэр _____

Зураг



1. Овог нэр (паспортад бичигдсэнээр)

2. Төрсөн газар, огноо

3. Иргэний харьяалал

4. Яс, үндэс

5. Хүйс

6. Боловсрол, мэргэжил (хаана, ямар сургуулийг хэдээс хэдэн онд суралцаж төгссөн)

7. Ажил эрхлэлтийн байдал (хаана, ямар байгууллагад хэдээс хэдэн онд ямар ажил хийж байсан, одоо ямар ажил хийж байгаа)

8. Ам бүлийн байдал (иргэний харьяалал, овог нэр, төрсөн огноо, оршин суугаа газар)

9. Шүүхээр шийтгэгдэж байсан эсэх (шийтгэгдэж байсан бол ямар ял шийтгэл хүлээж байсан)

10. Гадаадад улсад ямар зорилгоор хэдэн жил амьдарсан

11. Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох болсон шалтгаан

12. Таныг дагалдаж таны гэр бүлийн гишүүн Монгол Улсын харьяат болох эсэх

13. Амьжиргааны эх үүсвэр

14. Байнга оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг

Миний хамт Монгол Улсын харьяат болох
18-аас доош насны хүүхэд

№	Овог нэр	Хүйс	Төрсөн газар, он сар, өдөр	Ургийн холбоо
1				
2				
3				
4				

Мэдүүлгийн хуудсыг үнэн зөв бичсэн _____

20...оны ... сарын ...өдөр

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний
ерөнхий газрын даргын 2014 оны
№ 226 дугаар тушаалын IV хавсралт

Хар өнгийн бэхээр гаргацтай, үнэн зөв бөглөнө


МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТААС ГАРАХ
ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН МЭДҮҮЛГИЙН ХУУДАС

Овог _____

Эцэг (эхийн) нэр _____

Өөрийн нэр _____

Зураг



1. Овог, нэр (иргэний үнэмлэхэд бичигдсэнээр)

2. Төрсөн газар, огноо

3. Регистрийн дугаар

4. Хүйс

5. Яс, үндэс

6. Боловсрол, мэргэжил (хаана, ямар сургуулийг хэдээс хэдэн онд суралцаж төгссөн)

7. Ажил эрхлэлтийн байдал (хаана, ямар байгууллагад хэдээс хэдэн онд ямар ажил хийж байсан, одоо ямар ажил хийж байгаа)

8. Ам бүлийн байдал (иргэний харьяалал, овог нэр, төрсөн огноо, оршин суугаа газар)

9. Шүүхээр шийтгэгдэж байсан эсэх (шийтгэгдэж байсан бол ямар ял шийтгэл хүлээж байсан)

10. Монгол Улсын харьяатаас гарахыг хүссэн шалтгаан, харьяат болох хүсэлтэй улс

11. Харьяат болох улсын урьдчилсан зөвшөөрөл авсан огноо, хүчинтэй хугацаа

12. Таныг дагалдаж таны гэр бүлийн гишүүн Монгол Улсын харьяатаас гарах эсэх

13. Эх орондоо үлдэж буй эцэг эх, эхнэр/нөхөр, хүүхэд хэний асрамжинд байх

14. Монгол Улсын харьяатаас гарахыг эцэг эх, эхнэр /нөхөр/, хүүхэд зөвшөөрч байгаа эсэх

15. Байнга оршин суугаа улс, хотын нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг

16. Монгол Улсад холбоо барих хүн, утасны дугаар

Миний хамт Монгол Улсын харьяатаас
гарах 18-аас доош насны хүүхэд

№	Овог нэр	Хүйс	Төрсөн газар, он сар, өдөр	Ургийн холбоо
1				
2				
3				
4				
5				

Мэдүүлгийн хуудсыг үнэн зөв бичсэн _____

20...оны .. сарын ...өдөр

